## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, СҮМБЭР ЗАСАГ ДАРГА НАРЫН 2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Эхний хагас жилийн байдлаар/

**2022.05.25**

| № | Хэрэгжүүлэх үүрэг | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин /эхний хагас жил/ | Хэрэгжилтийн явц, үр дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 |
| 1 | Монгол улсын хуулийг чандлан сахиж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллан, байгууллагын хэмжээнд сахилга, хариуцлагыг сайжруулан, иргэдэд шуурхай, үр дүнтэй, шударга, ил тод, хүнд сурталгүй үйлчилж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх. | Ёс зүйн зөвлөлийг шинэчлэх, ажиллах журмыг шинэчлэн батлах, ёс зүйн чиглэлээр зохион байгуулах сургалтын төлөвлөгөө гаргах сургалт зохион байгуулах, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай болгох | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан албан хаагчдын хувь<br><br>Албан хаагчдын цаг ашиглалтын хувь | 2<br><br>24<br><br>100 | Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 02 сарын 23-ны өдрийн А/04 тушаалаар байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсан. 2022 онд ёс зүйн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын дунд хамт олонч зөрэг уур амьсгал, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ёс зүйтэй байх чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 46 албан хаагч хамрагдсан. Мөн "Миний сайн муу тал" саналын хуудас аялуулан, мөн 3 дугаар сарын "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулж ажиллаа.<br>Албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор TIMELY цаг бүртгэлийн ухаалаг платформыг 04 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглан уг бүртгэлээр нэмэлт төхөөрөмж ашиглахгүйгээр ажилтан Timely апп-аар ИРЭХ/ЯВАХ цагаа бүртгүүлж, дарга апп болон вебээр ажилчдын цаг бүртгэлийг бүрэн хянаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3**<br>**Хамрагдсан албан хаагчдын тоо 46**<br>**Цаг ашиглалт - 70** | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд "Аймгийн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл"-ийн 65 заалт, "Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 74 заалтыг бүрэн хэрэгжүүлж, тайланг хагас бүтэн жилээр хугацаанд нь гаргаж ирүүлэх. | Хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гаргаж, биелэлтэд ХШҮ хийж үр дүнг тооцон тайлагнах | Хяналтад авсан арга хэмжээний тоо<br><br>Гүйцэтгэлийн хувь | 2<br><br>80 | "Аймгийн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл"-ийн 2022 онд хэрэгжүүлэх суманд хамааралтай 95 заалт, "Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 81 заалтыг хяналтад авч ээнжүүлсэн. 2022 оны эхний хагас жилийн биелэлтийг гаргаж аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хяналтад авсан арга хэмжээний тоо-2 актын 176 заалт**<br>**Гүйцэтгэлийн хувь** -65,8 | 65,8 |
| 3 | Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого", эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, холбогдох арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлж үр дүнг тайлагнах. | "Шинэ сэргэлтийн бодлого", эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллах. | Хэрэгжилтийн хувь | 80 | Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого", эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 68,5 хувийн биелэлттэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Гүйцэтгэлийн хувь 68,5%** | 70 |
| 4 | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнийг дагалдан гарсан хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд сурталчлах, хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах. | Сумын харьяа байгууллага болон иргэдэд зохион байгуулах эрх зүйн албан бус сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулах | Зохион байгуулсан арга хэмжээ<br>Хамрагдсан иргэдийн тоо<br>Хамрагдсан байгууллагын тоо | 5<br><br>150<br><br>7 | Сумын хэмжээнд иргэдийн эрх зүйн албан бус боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгийг байгууллагын цахим хуудсанд байршуулан 89 иргэний хандалт авсан ба эрх зүйн хөтчийн булангаар дамжуулан 56 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан. Хөдөөгийн багийн 4,5,6-р багийн иргэдэд 3 удаа 500 иргэнд хууль сурталчлах ажлыг зохион байгуулж хөдөөгийн 100 малчин өрхөд "Богцтой мэдээлэл" хүргэж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3**<br>**Хамрагдсан иргэдийн тоо 500**<br>**Хамрагдсан байгууллагын тоо 3** | 73,3 |
| 5 | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, хэрэгжилтийг хуулийн хугацаанд ирүүлэх. | Сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70 | Сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь 7 зорилт, арга хэмжээтэй төлөвлөгдөн батлагдсан. 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 7 зорилт 80 арга хэмжээтэй баталж, хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | батлуулах, хэрэгжилтэд ХШҮ үн элгээ хийж үр дүнг тооцох | | | ханган үр дүнтэй зохион байгуулж эхний хагас жилийн байдлаар 80 хувьтай гүйцэтгэлтэй ажиллаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хэрэгжилтийн хувь-80%** | |
| 6 | Сумын стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж тайлагнаж ажиллах. | Сумын стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах | Сумын стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна | | Сумын Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг боловсруулж албан хаагчдад төслөөр танилцуулж, засварлах ажил хийгдэж байна. | 70 |
| 7 | Багийн Засаг дарга нарыг удирдлагаар хангах, үүрэг хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх. | Багийн Засаг дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэх | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | Сумын 6 багийн Засаг даргатай хамтран ажиллах хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж баталсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, тайлагнах аргачлалаар дотоод сургалт 1 удаа, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн"-өөр 1 удаа нийт 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 34 албан хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан сургалтын тоо 2** | 100 |
| 8 | Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. Иргэдийг мэдээллээр хангах, мэдээ мэдээллийг хурдан шуурхай хүргэх, аливаа уулзалт, зөвлөгөөн, хурал цуглаанд иргэдийн санал бодлыг сонсож шийдвэрлэж ажиллах. Аймаг, сумдаас зохион байгуулж буй арга хэмжээнд иргэдийг оролцуулах, хамруулах. Аймгийн govisumber.gov.mn цахим хуудсанд 7 хоног бүр үйл ажиллагааны мэдээ мэдээллийг байршуулах. | Иргэдтэй хэсэгчилсэн уулзалт зохион байгуулах, багийн Засаг дарга нарыг сар бүр 20 өрхөөр орж ажиллуулах, нээлттэй хаалганы өдөрлөгийн хуваарь гаргаж батлуулах, иргэдийн санал хүсэлтийг авах, шийдвэрлэсэн талаарх мэдээллийг 7 хоног тутам аймгийн болон сумын цахим хуудаст мэдээлэл байршуулах 14 хоног тутам | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан иргэдийн тоо<br><br>Байршуулсан мэдээ мэдээллийн тоо<br><br>Хандалтын тоо | 6<br><br>400<br><br>32<br><br>16000 | Сумын 6 багаас зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах төлөвлөгөө гаргаж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хөдөөгийн багийн иргэдтэй хийх уулзалтыг 6 удаа зохион байгуулж нийт давхардсан тоогоор 500 иргэнд бэлчээр ашиглалтын журам болон орон нутгаас авч хэрэгжүүлж буй ажлаар Авто тээврийн төв, Аймгийн мал эмнэлгийн газар, Номын сан, Татварын газар, Даатгалын компаниуд, Төрийн банк болон Хаан банк зэрэг 7 байгууллага оролцож цаг үеийн мэдээллийг хүргэсэн. Төвийн багийн өдөрлөгийг 1 удаа зохион байгуулж 123 иргэн, хэсэгчилсэн уулзалт, ярилцлагыг 4 удаа зохион байгуулж 36 иргэд нийт Багийн Засаг дарга нараас 3 удаагийн лайв мэдээллийг иргэдэд хүргэсэн. 14 хоног тутам мэдээлэл гаргаж аймгийн УАШЗ-д 11 удаа танилцуулагдаж байна.<br>**Хүрсэн түвшин:** | 82,7 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | аймгийн УАШЗ-д танилцуулах | | | **Зохион байгуулсан өдөрлөг, уулзалтын тоо 11**<br>**Хамрагдсан иргэдийн тоо 659**<br>**Багуудын фейсбүүк хуудаст байршуулсан мэдээллийн тоо 119**<br>**Хандалтын тоо** 4978 | |
| 9 | Төр, төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг сайжруулах, өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Төрийн хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж батлуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан ТББ-ын тоо | 4<br>4 | Орон нутагт Биеийн тамир спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 холбоо, мөн сумын Ахмадын хороо, Улаан загалмайн хороо, ДЗОУБ-тай хамтран дараах арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд:<br>1. Үндэсний бөхийн холбоотой хамтран Чойрын богд хайрханы хишиг барилдаан – 3,5 сая төгрөг<br>2. Говийн усчид клубтэй хамтран Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээн – 300,0 мянган төгрөг<br>3. Сансар хайрхан ширээний теннисний клубтэй хамтран Сумын засаг даргын нэрэмжит Ширээний теннисний тэмцээн -<br>4. Ахмадын спортын арга хэмжээнд – 2,0 сая төгрөг<br>5. ДЗОУБ-тай хамтран<br>➢ 17 өрхөд 34,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгосон.<br>➢ Зорилтот 110 өрхөд 10,6 сая.төг хүнсний тусламж<br>➢ 13 өрхийг малжуулах төсөлд хамруулж 260 толгой мал олгосон.<br>➢ Орон гэргүй 4 өрхөд 5 ханатай гэр олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 5**<br>**Хамтарсан байгууллагын тоо 5**<br>**Хамрагдсан иргэдийн тоо /давхардсан/-305**<br>**Төлөвлөгөөний гүйцэтгэл 70 %** | 70 |
| 10 | Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний соёл, угтах, үдэх үйлчилгээний чанарт анхаарах, төрийн | Чанарын менежментийн тогтолцоо" ISO 9001 2015 олон улсын | | 80 | Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-тай сумын Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаанд үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, ISO 18091:2020 стандарт | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын үйл ажиллагаанд ISO MNS 9001:2016 "Чанарын удирдлагын тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх чиглэлээр санаачлаг гарган ажиллах. Сумдад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад стандартыг сурталчлах. | стандарт нэвтрүүлсэн эсэх | Чанарын менежментийн тогтолцоо" ISO 9 001:2015 олон улсын стандарт нэвтрүүлж баталгаажсан байна. | | нэвтрүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх байгууллагын чанарын багийн 4 албан хаагч 5 хоногийн вакуумжуулсан сургалтад хамруулж стандартыг баримт бичгийг боловсруулаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх ажлын гүйцэтгэл 70 хувь** | |
| 11 | Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлага, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах. | Ёс зүйн зөвлөлийг шинэчлэх, ажиллах журмыг шинэчлэн батлах, ёс зүйн чиглэлээр зохион байгуулах сургалтын төлөвлөгөө гаргах сургалт зохион байгуулах, | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан албан хаагчдын тоо<br><br>Албан хаагчдын цаг ашиглалтын хувь | 2<br><br>24<br><br>100 | Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 02 сарын 23-ны өдрийн тушаалаар байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан уг зөвлөлийн ажиллах журам болон төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын дунд хамт олонч зэрэг уур амьсгал, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, "Ёс зүйн зөвлөл"ийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулах зорилгоор "Өглөөний цай" арга хэмжээг зохион байгуулан уг арга хэмжээний үеэр ёс зүйн зөрчил шалгах үндэслэлийн талаар сургалт зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн эрхэмлэх ёс зүйл" боршур тараан, албан хаагчдын дунд "Миний сайн муу тал" саналын хуудас аялуулан, мөн 3 дугаар сарын "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулж ажилласан. Албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор TIMELY цаг бүртгэлийн ухаалаг платформыг 03 сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглан, уг бүртгэлээр нэмэлт төхөөрөмж ашиглахгүйгээр ажилтан Timely апп-аар ИРЭХ/ЯВАХ цагаа бүртгүүлж, дарга апп болон вебээр ажилтнуудынхаа цаг бүртгэлийг бүрэн хянаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3**<br>**Хамрагдсан албан хаагчдын тоо 46** | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Цаг ашиглалт 70 хувь** | |
| 12 | Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тогтмол оролцож, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар болон аймгийн Засаг даргаас хууль, тогтоомжийн хүрээнд өгсөн шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, үр дүнг тайлагнах. | Шуурхай зөвлөгөөний үүргийн биелэлтийг бүрэн хангуулж, үр дүнг тооцон 14 хоног тутам хүргүүлэх | Шуурхай зөвлөгөөнд өгсөн үүрэг даалгаврын тоо<br>Үүргийн биелэлтийн хувь | 10<br>100 | Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 11 удаа оролцож, тухай бүр Сумын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг бэлтгэн танилцуулж, шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 8 удаагийн 22 үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг 97.1 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Өгөгдсөн үүргийн тоо 22**<br>**Гүйцэтгэлийн хувь 97,1** | 97,1 |
| 13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгон хэрэгжүүлэх, албан хэрэг хөтлөлтөд уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх. | Байгууллагын архивын баримт бичгийг янзлах, Монгол бичгийн сургалтыг албан хаагчдад зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Хамрагдсан албан хаагчдын тоо<br>Гүйцэтгэлийн хувь | 4<br>24<br>100 | Байгууллагын архивын баримт бичгийг цэгцлэх хүрээнд 3-р багийн иргэн Батчимэгтэй гэрээ байгуулж байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 1996-2021 оны 244 баримт, 70 жил хадгалах 1974-2021 оны 86 баримтыг стандартыг дагуу цэгцэлж нийт 330 баримтыг аймгийн Төрийн архивд шилжүүлсэн. Устгах 1980-2021 оны 260 баримтыг аймгийн баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн. Байгууллагын захирамж тушаал ирсэн бичиг, явсан бичгийн хавтсыг монгол бичгээр нүүрлэсэн. Байгууллагын дотоод сургалтаар 2 удаа сургалт зохион байгуулж 32 албан хаагч хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2**<br>**Хамрагдсан албан хаагчдын тоо 32**<br>**Архивын ажлын гүйцэтгэл – 100%** | 83,3 |
| 14 | Албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулах, байгууллагын албан хэргийн үйл ажиллагаанд Монгол бичгийн программ хангамжийг нэвтрүүлэх. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хаягийг | Монгол бичгийн сургалт, арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө гаргаж батлуулах, монгол бичгийн программ хангамжийг нэвтрүүлэх, албан | Анхан шатны түвшний мэдлэгтэй ТАХ-ийн эзлэх хувь<br>Монгол бичгээр байгууллагын хаягийг сольсон тоо | 30<br>1<br>6<br>300 | Албан хаагчдын монгол бичгийн түвшинг тогтооход анхан шатны мэдлэгтэй албан хаагч 46,5 хувийг эзэлж байна. Монгол бичгийн хэрэглээг нэвтрүүлэх суралцах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу 5 удаагийн сургалт зохион байгуулж 165 албан хаагчийг хамруулсан. Сумын хэмжээнд сургагч багшаар 1-р сургуулийн Лоохууз багш ажиллаж байгаа | 70,8 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх. | хэргийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх | Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан албан хаагчдын тоо | | бөгөөд арга зүйгээр тогтмол хангаж байна. Сумын хэмжээнд 3 сургууль, 4 цэцэрлэг, сумын ЗДТГ, ИТХ байгууллагын хаягаа бүрэн шинэчилж сольсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Анхан шатны түвшний мэдлэгтэй ТАХ-ийн эзлэх хувь – 46,5**<br>**Зохион байгуулсан сургалтын тоо 5**<br>**Хамрагдсан албан хаагчдын тоо 165**<br>**Хаягаа сольсон байгууллагын тоо 9**<br>**Монгол бичигт суралцах төлөвлөгөөний гүйцэтгэл 50 хувь** | |
| 15 | Байгууллагын дотоод удирдлагын ERP систем нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, төрийн үйлчилгээг цахим e-mongolia системд холбох, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх, өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Сумын Засаг даргаас олгох тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг e-mongoia системд болон байгууллагын цахим хуудаст оруулах, өргөдөл гомдлыг цахимд шилжүүлэх, байгууллагын дотоод удирдлагын ERP системийн үйл ажиллагааг тогтмолжуулах | Албан хэрэг хөтлөлтийн цахимжуулалтын хувь<br>e-mongolia системд орсон үйлчилгээний тоо<br>олгосон лавлагааны төрөл<br>лавлагааны тоо<br>цахимаар хүлээж авсан өргөдлийн тоо<br>Шийдвэрлэлтийн хувь | 100<br>2<br>24<br>500<br>100 | Erp системд 138 албан бичиг ирсэн үүнээс шийдвэрлэсэн 79, судлагдаж байгаа 22, эргэн танилцах 1, хугацаа дөхсөн 2, хугацаа хэтэрсэн 1, буцаасан 25 албан бичиг байна. Нийт 26 албан хаагч erp системийг өдөр тутамд бүрэн ашиглаж байна.<br>E-mongolia системээр 522 иргэн үйлчлүүлсэн 28 төрлийн лавлагааг 392 иргэнд олгосон. Олгосон лавлагааны 66,5 хувь нь оршин суугаа хаягын лавлагаа эзэлж байна. Цахимаар ирсэн 3 хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Албан хэрэг хөтлөлтийн цахимжуулалтын хувь – 70,6**<br>**e-mongolia системд шинээр орсон үйлчилгээний тоо - 1**<br>**Олгосон лавлагааны төрөл - 28**<br>**Лавлагааны тоо - 522**<br>**Цахимаар хүлээж авсан өргөдлийн тоо -4**<br>**Шийдвэрлэсэн – 2**<br>**Шийдвэрлэх шатандаа - 2**<br>**Шийдвэрлэлтийн хувь - 100** | 90 |
| 16 | Хөдөөгийн багийн иргэдийг цахимаар төрийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлэх, хөдөөгийн багийг интернет сүлжээнд холбох, төрийн | 5,6-р багийг интернет сүлжээнд оруулах, төрийн үйлчилгээний цахим e-mongolia системийг иргэдэд сурталчлах | Интернет сүлжээнд холбох багийн тоо<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо | -<br>2 | 6-р багт жи мобиалын 4 жи интернет сүлжээ оруулах ажил гүйцэтгэлийн шатандаа байна. Хөдөөгийн малчдад 3 удаагийн багийн иргэдийн нийтийн хурал, уулзалтаар e-mongolia системийг ашиглаж хэрхэн лавлагаа мэдээлэл авах талаар нийт 196 малчинд арга зүйн зөвлөгөө өгч 236ш гарын авлага тараасан. | 76,6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний цахим e-mongolia системийг иргэдэд сурталчлах. | гарын авлага бэлтгэж тараах | Хамрагдсан иргэдийн тоо | 150 | **Хүрсэн түвшин:**<br>**Интернет сүлжээнд холбогдох багийн тоо 1**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3**<br>**Хамрагдсан иргэдийн тоо 196** | |
| 17 | Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн, мэдээ, мэдээллийг иргэдэд цахим хуудас, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэх, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах. | Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангуулж, цахим хуудасны баяжилт шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж ил тод байдлыг хангуулах | Цахим хуудасны баяжилтын хувь, хандалтаар | 90<br><br>1600 | Байгууллагын цахим хуудсанд 463 мэдээлэл оруулахад 2150 хандалттай, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт"-ийн дагуу байгууллагын цахим хуудаст баяжилт хийж байна. Сүмбэрийн мэдээ, Сүмбэр сумын засаг даргын Тамгын газар фейсбүүк хуудаст 1002 мэдээлэл оруулсан байна. Хандалтын хүмүүсийн эрэгтэй 42,1 хувь, эмэгтэй 57.9 хувийг эзэлж байна. Байгууллагын цахим хуудасны баяжилт бүрэн дуусаагүй гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байна. Цахим хуудасны засвар мэдээллийн баяжилт бүрэн хийгдэж дуусаагүй байгаа учраас хандалтын тоо зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй байна.<br>**Хүрсэн түвшин: хэрэгжилтийн хувь-50** | 70 |
| 18 | Төрийн албан хаагчдыг сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдыг богино хугацааны мэргэшүүлэх болон төрийн албанд анх орсон иргэдийг мэргэшүүлэх анхан шатны, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, дунд шатны давтан сургалтад хамруулах. | Төрийн албан хаагчдыг сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах хөтөлбөр боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөө баталж хэрэгжилт үр дүнг тооцох | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан албан хаагчдын хамрагдалтын хувь | 11<br><br>100 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгаа хангах арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж Тамгын газрын даргын 2022 оны А/07 тоот тушаалаар баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг 91.3 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор 10 удаагийн дотоодын мөн бусад байгууллагаас 3 удаагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 200 албан хаагч, Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 2 албан хаагч, хамрагдсан. Мөн 3 албан хаагчид дотоод журмын дагуу 1,250.0 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлэн, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 27 албан хаагчдад 680,0 төгрөгийн витаминжуулалтын багц олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан сургалтын тоо 10** | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хамрагдсан албан хаагчдын тоо 200 | |
| 19 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж, төрийн албан хаагчийг хууль бусаар томилж чөлөөлөхгүй байх, Засаг даргын Тамгын газрын албан хаагчийн нөөцийг бүрдүүлэн хуулийн дагуу сул орон тоог нөхөх. | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчил гаргахгүй байх, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчийн нөөцийг бүрдүүлэн сул орон тоог хуулийн дагуу нөхөх | Хуулийн хэрэгжилтийн хувь | 100 | Төрийн албанд хууль бус томилгоо хийгдээгүй. Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй түр томилготой 5 албан хаагчийг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу ажлаас чөлөөлж сул орон тооны захиалга судалгааг аймгийн ТАЗСЗ-д хүргүүлсэн. Төрийн албаны тусгай шалгалтаар 3 орон тоо нөхөгдсөн. Төрийн захиргааны албан тушаалын 7 орон тоо сул нөхөгдөхгүй шалгалтад хүн орохгүй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Сул орон тоо тусгай шалгалтаар 2 орон тоо нөхөгдсөн. 7 орон тоо бүрэн нөхөгдөөгүй.** | 70 |
| 20 | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөхдөө салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, иргэн хуулийн этгээдийн саналыг авч тусгах. | 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг иргэдээс цахим болон цаасаар нийт хүн амын 50 хувиас дээш авч нэгтгэн баг тус бүр ИНХ-аар эрэмбэлүүлэх, сумын нэгдсэн жагсаалтыг бэлтгэж батлуулах | Санал өгөх иргэдийн тоо | 55% | ОНХС-ын саналыг авахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу иргэдээс саналын хуудсаар болон мэдээлэл технологийн аргаар санал авч байна. Нийт санал өгөх ...... иргэнээс 1110 хүний саналыг авч тусгасан<br>**Хүрсэн түвшин:**<br>**Санал өгсөн иргэдийн тоо-1110** | 70 |
| 21 | Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулан, нийтийн эзэмшлийн хөрөнгийг арчилж, хамгаалах, ээлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хөрөнгийг бүртгэлжүүлэх, хяналт тавих | Бүртгэгдсэн хөрөнгийн тоо, гүйцэтгэлийн хувь | 100 | 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг харьяалах байгууллагуудын эд хөрөнгө бүртгэлжүүлэх Сумын даргын захирамжаар нийт 13 хөрөнгө оруулалтын ажлын 476,625,711 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 7 байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд 100 хувь бүртгэлжүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Бүртгэгдсэн хөрөнгийн тоо 13**<br>**Гүйцэтгэлийн хувь 100** | 100 |
| 23 | Сумдын төвийн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, золбин муур нохой устгах хариулгагүй малыг | 3-р багийн нутаг дэвсгэр Баянбулагийн эгнээнд гэрэлтүүлэг хийх, золбин нохой муур устгах ажлыг 3 | Шинээр хийгдсэн гэрэлтүүлгийн тоо | 100<br><br>300<br><br>2 | Сүмбэр сумын 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх "3-р багийн нутаг дэвсгэр Баянбулагийн эгнээнд гэрэлтүүлэг хийх ажил"-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан. Тус | 73,3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сумын төвөөс гаргах ажлыг үр дүнтэй зохион байгуулах. | удаа зохион байгуулах, төвд байгаа хариулгагүй малын эздийг тогтоож цагдаагийн байгууллагад мэдэгдэж арга хэмжээ тооцох, төвөөс гаргах арга хэмжээ авах | Устгасан нохой муурны тоо<br><br>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | | тендерт шалгарсан "Оджи од"ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 04 сарын 27-ны өдөр байгуулсан. Гүйцэтгэлийн ажил 05 сарын 23-ны өдрөөс эхлэхээр төлөвлөгдөөд байна.Сумын Засаг даргын 04.15-ны өдрийн А/67 дугаар захирамжийн дагуу "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГазар нь золбин нохой, муур устгалын ажлыг 04.18-20-ний өдрийн хооронд зохион байгуулж, 311 золбин нохой, 32 муурыг 6.860.000 төгрөгийг зарцуулан устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийн булж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Шинээр хийгдэх гэрэлтүүлгийн тоо – 100**<br>**Устагсан нохойны тоо – 311**<br>**Устагсан муурны тоо – 32**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1.** | |
| 24 | "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд зохион байгуулж, аж ахуйн нэгж иргэдийн оролцоог хангах. | "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж батлуулах, хэрэгжилт үр дүнг танилцуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Тарьсан модны тоо<br><br>Ургалтын хувь | 4<br><br>5000<br><br>70 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд мод тарих хөдөлгөөн 05 сарын 27 хүртэл үргэлжлэх ба 05 сарын 20-ны байдлаар хаврын мод тарилтын ажлыг төрийн 34 байгууллага 1040 мод, хувийн хэвшлийн 11 байгууллага 608 мод, сумын 6 багийн 204 иргэн 1008 мод, замын баруун талд үйлдвэрлэлийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй 18 байгууллагаас 5 байгууллага 1500 мод нийт 50 ААН байгууллага 4156 мод шинээр тарьсан. Тарьсан модны нахиа задралт 50 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 5 удаагийн уулзалт ярилцлага хийсэн.**<br>**Шинээр тарьсан модны тоо 4156**<br>**Ургалтын хувь / нахиа задарсан байдал /- 50** | 90 |
| 25 | Суманд мод үржүүлгийн газар байгуулах чиглэлээр судалж, шийдвэрлэх. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нэзлттэй 425-р хорих ангитай хамтран 5га газарт мод үржүүлгийн газар байгуулах | Шинээр байгуулсан мод үржүүлгийн газрын хэмжээ | 5 га | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нэзлттэй 425-р ангитай хамтран 5 га газарт мод үржүүлгийн газар байгуулж, төлөвлөгөө гаргаж баталсан. Үржүүлгийн газарт ОНХС-ийн хөрөнгө оруулалтаас 30,0 сая төгрөгийн усалгааны систем, тарьц суулгац, үрийг бэлтгэсэн. Сумаас 6х20 хэмжээтэй 2 хүлэмж олгосон | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Хүрсэн түвшин:**<br>**Шинээр байгуулсан мод үржүүлгийн газрын тоо 1** | |
| 26 | Сумын нутаг дэвсгэрт ойн зурвас байгуулах, мод бут арчлалт, хамгаалалтыг сайжруулж, ургалтын хувийг нэмэгдүүлэх. | Сумын нутаг дэвсгэрт ойн зурвас албан байгууллагын оролцоотой 3400 модны нөхөн тарилт хийнэ. | Шинээр тарьсан модны тоо-<br>Нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ /га/<br>Ургалтын хувь- | 3400<br>6 га<br>90% | Хагас жилийн байдлаар ойн зурваст төрийн 34 байгууллага 1040 мод, хувийн хэвшлийн 19 байгууллага 980 мод, бутыг тарьж усалгаа арчилгааг тогтмол хариуцан ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Шинээр тарьсан модны тоо 2020**<br>**Нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ- 7.8 га**<br>**Ургалтын хувь-50%** | 81,6 |
| 27 | Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах төлөвлөгөө гаргаж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Өнгө нэм ТББ-тай хамтран орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах чиглэлээр сумын хог хаягдлын нэгдсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлнэ. | Гүйцэтгэлийн хувь | 50 | "Өнгө нэм" ТББ-тай хамтран сумын хэмжээнд хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бий болгох зорилгоор ОНХС-ийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 сарын хугацаатай "Хог хаягдлын менежментийн тогтвортой хэрэгжүүлэх" төсөлд хамтран ажиллах гэрээ байгуулж, суурь судалгааг бүрэн хийгдэж төлөвлөлтийн шатанд явагдаж байна. Сум хэмжээнд "Дахивар авах өдөрлөг", "Зүгээр битгий хая" аяныг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Гэрээ хэлцэл байгуулсан. Хөрөнгийг бүрэн шийдвэрлэсэн.**<br>**Гүйцэтгэл 46,8%** | 50 |
